



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 465

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 нэрийн, нийт 24,729,816.00 (хорин дөрвөн сая долоон зуун хорин есөн мянга найман зуун арван зургаан) төгрөгийн балансын үнэ, 8,389,023.27 (найман сая гурван зуун наян есөн мянга хорин гурван төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Н.Гансүх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003352  
25-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

"ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ" ТӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
 ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк, загвар	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
2	Принтер	HP-M1200A	2021.12.27	1	720,000.00	720,000.00	59,145.00	660,855.00
3	Принтер	HP laser 107a	2021.12.27	3	393,272.00	1,179,816.00	96,921.00	1,082,895.00
4	Суурин компьютер	Dell optiplex 7090	2022.03.09	7	2,850,000.00	19,950,000.00	7,996,377.27	11,953,622.73
						<b>24,729,816.00</b>	<b>8,389,023.27</b>	<b>16,340,792.73</b>
						(хорин дөрвөн сая долоон зуун хорин есөн мянга найман зуун арван зургаан)	(найман сая гурван зуун наян есөн мянга хорин гурван төгрөг хорин долоон мөнгө)	(арван зургаан сая гурван зуун дөчин мянга долоон зуун ерэн хоёр төгрөг далан гурван мөнгө)

Нийт дүн